

Онгон сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын

2021.04 дүгээр сарын мэдээ

Нэг: Удирдлага зохион байгууллалтын чиглэлээр.

Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

- ✓ Коронавируст цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд 4 удаа сумын Онцгой комиссыг хуралдуулж цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллаа.
- ✓ Суманд коронавирусын 11 тохиолдол бүртгэгдэж сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/44 тоот захирамжаар Тэг зогсолт хийх шийдвэр гаргаж ажиллаж байна.
- ✓ Цар тахлын үед нийт 5 суурин пост, 18 албан хаагч хуваарийн дагуу эргүүл хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна. Давхардсан тоогоор 57 албан хаагч Онцгой нөхцөлд ажиллаж байна.

Хоёр: Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд.

- ✓ Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг хэрэгцээт үед нь тогтмол гарган өгч байна.
- ✓ Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй болон ажиллаа.
- ✓ Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгч байна.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд.

- ✓ Цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрүүдийг ард иргэдэд сурталчилах ажлыг Сум дундын эмнэлэг, Мэдээлэл сургалт сурталчилгааны багтай хамтран 150 ширхэг тараах материал, 50 ширхэг анхааруулга, заавар зөвлөмжийг бэлтгэн иргэдэд тарааж ажиллаа.

Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- ✓ Сургууль цэцэрлэг ажиллахгүй байгаа нөхцөлд Аймаг сумаас зохион байгуулж буй цахим уралдаан тэмцээнүүдийг 3 удаа зохион байгууллаа.
- ✓ Монгол бичгийн цахим сургалтыг ЕБСургуулийн Молнгол хэлний багш Д.Сэргэлэн, Ц.Урангоо нар хамтран бүх төрийн албан хаагчидад зааж сургах ажлыг зохион байгуулж байна. Уг үйл ажиллагаанд нийт 49 албан хаагч хамрагдаж байна.
- ✓ Нэгдүгээр ээлжийн вакцинийг хуваарийн дагуу бүх төрийн албан хаагч, Онцгой байдлын албан хаагчидад бүрэн тарьж дууссан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

- ✓ Мал амьтаны сэг зэмийг устгах ажлын хүрээнд сум тойрсон үхсэн мал 52 ширхэг, нохой муур, зэрлэг амьтан 16 ширхэгийг ОНӨААТҮГазар, багийн Засаг дарга нар, сургуулийн барилгын албан хаагчидтай хамтран бүрэн цэвэрлэж ариутгал халдваргүйтгэл хийж устгалаа.
- ✓ МУЕ-ын зарлигийн дагуу бүх өрхийг мод тарих аянд уриалж нэг өрх нэг мод аян зарлаж Сүхбаатар аймгийн Мод үржүүлгийн компаниудтай хамтран ажиллаж байна. Ард иргэдээс одоогоор модны захиалга авч байгаа бөгөөд хөл хорио сулрах үед захиалсан модуудыг татан авч ирж тарих ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.АДЪЯА